

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР
“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ
БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭНД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2022 оны эхний хагас жилийн байдлаар/**

2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилго, зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүй

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 4 зорилтын 20 арга хэмжээний хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

УУХҮЯ-ны хэрэгжүүлэх 4 зорилтын 20 арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа бөгөөд 2022 оны хагас жилийн биелэлт **56.43** %-тай дүгнэгдэв.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилгоор нь авч үзвэл:

- Зорилт 4.1. “Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоно” зорилтын биелэлт **30.0** хувьтай.
- Зорилт 4.2. “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно” зорилтын биелэлт **56.0** хувьтай.
- Зорилт 4.4. “Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнэ зорилтын биелэлт” **30.0** хувьтай.
- Зорилт 4.6. “Эдийн засгийн төрөлжилт, инновац, шинэ технологи, хүний хөгжил, ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих чадавхтай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг бий болгоно” зорилтын биелэлт **85.0** хувьтай дүгнэгдлээ.

**Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар “Алсын хараа-2050”
Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга
хэмжээний хэрэгжилт
/2022 оны эхний хагас жилийн байдлаар/**

Хүснэгт 1

Зорилт	Кс	Үнэлгээ (хувь)				Хугацаа Болоогүй	Хэрэгжилт (хувь)
		30	70	50	90		
Зорилт 4.1. Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоно	1				1		30.0%
Зорилт 4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно	10		3		4	3	56.0%
Зорилт 4.4. Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө	1					1	30.0%
Зорилт 4.6. Эдийн засгийн төрөлжилт, инновац, шинэ технологи, хүний хөгжил, ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих чадавхтай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг бий болгоно	8	1		1		6	85.0%
Нийт			3		4	5	58.43%

2022 оны хагас жилийн байдлаар хэрэгжилт хангалтгүй 5 арга хэмжээ байна. Үүнд:

- 4.1.17. Алт цэвэршүүлэх үйлдвэр болон бусад технологийн түүхий эдэд суурилсан гадаадын томоохон хөрөнгө оруулалтыг татах замаар эдийн засгийн экспоненциал өсөлтийг бий болгоход анхаарч ажиллана.
- 4.2.13. Уул уурхайн түүхий эдийг боловсруулан, нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг байгаль орчинд ээлтэй, тогтвортой байх зарчмаар хөгжүүлж, хөрөнгө оруулалтын дэвшилтэт хэлбэрүүдийг дэмжинэ.
- 4.2.15. Говийн бүс рүү ус дамжуулах хоолой барьж байгуулна.
- 4.2.17. Гадаад, дотоод зах зээлд чиглэсэн гүн боловсруулалтын технологид суурилсан хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- 4.4.12. Дотоодын боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг гадаад өрсөлдөөнөөс хамгаалах бодлого зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Эдгээр 5 төсөл, арга хэмжээний хэрэгжилт зорилтот түвшиндээ хүрээгүй, боловсруулалтын шатанд байгаа буюу 30 хувиар үнэлэгдлээ.

2022 оны хагас жилийн байдлаар хэрэгжих хугацаа болоогүй 6 арга хэмжээ байна. Үүнд:

- 4.6.2. Баялгийн сангийн засаглалын зохистой зарчмуудыг тодорхойлж, холбогдох дүрэм, журмыг батлуулна.
- 4.6.3. Баялгийн сангийн тухай хуульд заасан орлогын эх үүсвэрээс санд хөрөнгө төвлөрүүлж, хуульд заасан арга хэлбэрээр хөрөнгийг арвижуулна.
- 4.6.4. Сангийн тухайн жилийн нийт хөрөнгийн зарим хэсгийг олон улсын санхүүгийн зах зээл дээр зээлжих зэрэглэл нь “АА” болон түүнтэй адилтгах

үнэлгээтэй, өгөөж нь тодорхой санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийж эхэлнэ.

4. 4.6.5. Сангийн хөрөнгөөс том хэмжээний төсөлд, эсхүл эдийн засгийн төрөлжилтийг хангах, иргэдийн аюулгүй байдал, тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн төсөлд хөрөнгө оруулалт хийж эхэлнэ.
5. 4.6.7. Иргэдийн аюулгүй байдал, тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгмийн хөгжлийг дэмжих төслүүдэд хөрөнгө оруулалт хийнэ.
6. 4.6.10. Мэдлэгийн эдийн засгийг дэмжих зорилго бүхий хөрөнгө оруулалтын шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлнэ.

Дөрөв. Дүгнэлт

1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээ, төслүүдийн хэрэгжилт 2022 оны эхний хагас жилийн байдлаар 56.43 хувиар үнэлэгдэв.
2. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээгээр 2022 оны эхний хагас жилийн байдлаар "бүрэн хэрэгжсэн"-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан 4 /90%, 100%/, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 1 /70%/, эрчимжүүлэх шаардлагатай 4 /50%/, хэрэгжилт хангалтгүй 6 /30%/, хэрэгжүүлж эхлэх хугацаа болоогүй 6 арга хэмжээ тус тус байна.

Тав. Санал, зөвлөмж

1. Хариуцсан нэгжүүд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээг тухайн салбарт хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг яаралтай батлан хэрэгжилтийг ханган ажиллах.
2. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг тайлагнахдаа "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Шинэ сэргэлтийн бодлого" зэрэг баримт бичгүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлттэй уялдуулан тайлагнаж хэвших.
3. Бодлогын баримт бичгийн хэрэгжилттэй шалгуур үзүүлэлтийн тайланг хамт тайлагнаж байх.


Хянасан:

ХШУДАГ-ын дарга

 Ц.Одхүү

Танилцуулга боловсруулсан:

ХШУДАГ-ын ахлах шинжээч

 Х.Цэнд-Аюуш /2022.06.30/

“Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

2022 оны хагас жил

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
Дөрөв. ЭДИЙН ЗАСАГ							
1	4.1. Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоно.	4.1.17. Алт цэвэршүүлэх үйлдвэр болон бусад технологийн түүхий эдэд суурилсан гадаадын томоохон хөрөнгө оруулалтыг татах замаар эдийн засгийн экспоненциал өсөлтийг бий болгоход анхаарч ажиллана.	2020 - 2050			<p><i>Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах:</i></p> <p>- Засгийн газрын 2017 оны 88 дугаар тогтоолоор “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний талаар хэлцэл хийх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Сангийн сайд, Үндэсний хөгжлийн газар /хуучнаар/-ын даргад тус тус даалгасны дагуу “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах аргачлал” болон хөрөнгө оруулалтын гэрээний төслийг боловсруулж хамтран батлуулахаар Сангийн яам болон ЭЗХЯ-нд хүргүүлсэн бөгөөд Сангийн яамнаас хамтран батлах шаардлагагүй талаар хариу ирүүлсэн бол, ЭЗХЯ-аас хариу ирүүлээгүй байна.</p> <p>- Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөлд “Оюутолгой” ХХК, “Рио Тинто Монгол” ХХК-иуд хөрөнгө оруулж, хамтран ажиллах болон Хөрөнгө оруулалтын гэрээний 3.21-д заасан техникийн шалгуур үзүүлэлтүүдийн талаар санал ирүүлэх тухай УУХҮ-ийн сайдын 2022.04.18-ны өдрийн 01/1085, 2022.04.26-ны өдрийн 01/1179 дугаар албан бичгүүд хүргүүлсэн. Харин “Рио Тинто Монгол” ХХК-ийн зүгээс “зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахад эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах, шаардагдах хөрөнгө оруулалт татах боломжийг судлах ажлыг хийж гүйцэтгэх” талаар хариу ирүүлсэн бөгөөд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Рио Тинто Монгол” ХХК хооронд</p>	30

					<p>харилцан мэдээлэл солилцох, мэдээллийг ашиглах хүрээнд “Нууцлалын гэрээ” байгуулаад байна.</p> <p>- “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төсөл”-ийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх ажлын хүрээнд АНУ-ын хөрөнгө оруулагчдад төслийг танилцуулах ажлыг зохион байгуулж, “төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах аргачлал” болон “хөрөнгө оруулалтын гэрээ”-ний төслийг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг /USAID/, Азийн товчооны гэрээ хэлцэлд зөвлөгөө өгөх сантай хамтран олон улсад мөрдөгдөж байгаа жишиг аргачлалын дагуу боловсруулж, хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах ажлыг 2022 оны III улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>- Төслийн ажлыг эрчимжүүлэн, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх хүрээнд “Эрдэнэс Оюутолгой” ХХК-иас ажлын хэсэг байгуулах асуудлаар хүсэлт ирүүлсний дагуу УУХҮ-ийн сайдын 2022.04.28-ны өдрийн 01/1233 тоотоор нэрс хүргүүлсэн.</p> <p><i>Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэр байгуулах:</i></p> <p>БНКаЗУ-ын “Сымбат инженеринг” компанийн боловсруулсан үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ, төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/100 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд ажлын хэсгийн дүгнэлтийг 2021.12.09-ний өдөр ирүүлсэн. Үүний дагуу төслийг хэрэгжүүлэх чиглэлээр 2022 онд гүйцэтгэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.7.7 дахь хэсэгт заагдсан арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан гаргаж, баталгаажуулах, үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх болон төсөл хэрэгжүүлэгчийг нээлттэй сонгон шалгаруулах ажлыг 2022 оны I улиралд багтаан зохион байгуулахаар тус төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг ханган талаар УУХҮ-ийн сайдын 2022.01.06-ны өдрийн 01/43 дугаартай албан бичгийг “Эрдэнэс Монгол” ХХК-д хүргүүлсэн. Мөн үйлдвэрийг барьж байгуулах олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын ажлын даалгавар боловсруулах ажлын хэсгийг “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн захирлын тушаалаар байгуулсан. Ажлын даалгавар боловсруулах ажлын хэрэгжилт 90 хувьтай.</p>	
--	--	--	--	--	--	--

2	4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.	4.2.1. Нэмүү өртөг шингээсэн уул уурхай, стратегийн мега төслүүд, боловсруулах аж үйлдвэр, хөдөө аж ахуй, эрчим хүч, тээвэр, логистик, төрөлжсөн аялал жуулчлал, түүнийг дагасан үйлчилгээ, жижиг, дунд үйлдвэрлэл, мэдлэгжсэн бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.	2020 - 2050		<p>Уул уурхайн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 20 гаруй хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 70 хувь, экспортын орлогын 94 хувь, улсын төсвийн орлогын 30 орчим хувийг тус тус бүрдүүлэгч эдийн засгийн гол тулгуур салбар болсон.</p> <p>Төсвийн тухай хуулиар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 65%-ийг ирээдүй өв санд, 30%-ийг төсвийн тогтворжуулалтын санд, 5%-ийг холбогдох аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилж байна.</p> <p>Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлэх нийт орлогын 73 хувь нь уул уурхайн салбараас төвлөрүүлж байна.</p> <p>Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлж байгаа орлогын бүтцийг салган авч үзвэл, дотоодын НӨАТ-ын 5%, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30%, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 5%, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 100%, олон улсын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгчийн төлсөн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10%, ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50% байна.</p> <p>Өөрөөр хэлбэл, Монгол Улсын 21 аймаг, 365 сум бүр дээр дурдсан Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаар дамжуулан уул уурхайн салбараас тодорхой хэмжээний төсвөө бүрдүүлж байна.</p> <p>“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө 4.2.14, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.2.11, Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.7, Шинэ сэргэлтийн бодлого 2022-2025 зэрэг МУ-ын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Хүнд үйлдвэрийн салбарын хөгжлийг хангахад чиглэсэн зорилт арга хэмжээг тусгагдсан. Энэ хүрээнд “Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор үйлдвэрлэл, технололгийн парк”, Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр” болон “Исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл”, Оюутолгойн ордыг түшиглэн “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл”, Дархан-Уул аймагт “Монгол ган цогцолбор-1” төсөл, “Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэр”, “Алтанширээт аж үйлдвэрийн парк” гэх зэрэг Хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт техник, технологи, инновацид суурилсан</p>	50
---	---	---	-------------	--	--	----

					нэмүү өртөг шингэсэн, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, дотоодын бүтээн байгуулалтын хэрэгцээг хангаж, шинээр ажлын байр бий болгох мега төслүүдийг ШСБ-ын хөгжлийн төслүүдийн жагсаалтад оруулж, төслийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан төслийн хэрэгжилт, явцын талаар 7 хоног бүр төсөл хэрэгжүүлэгчээс тайлан авч, ЭЗХЯ-нд хүргүүлэн ажиллаж байна.	
3	4.2.11. Уул уурхайн салбарыг байгальд хал багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлнэ.	2020 - 2050			Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын дунд байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөлгүй техник, технологи ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа шилдэг аж ахуйн нэгж байгууллагыг жил бүрийн жилийн эцэст шалгаруулан урамшуулах ажлыг зохион байгуулж байна. Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн ордод өнөөгийн байдлаар Төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” ХК, орон нутгийн өмчит “Тавантолгой” ХК, хувийн хэвшлийн “Энержи ресурс” ХХК-иуд ажиллаж байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг түшиглэн нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станц, Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслүүд хэрэгжиж байна. Дээр дурдсан төслүүд хэрэгжсэнээр олборлолт, боловсруулалт, борлуулалтын түвшин нэмэгдэж, цахилгаан эрчим хүчний хэрэгцээг дотоодоос хангах, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай тээврийн дэд бүтэц бүрдэх боломж бүрдэх юм.	90
4	4.2.12. Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг чанд мөрдөнө.	2020 - 2050			Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа гадаад, дотоодын стандартыг мөрдөн ажиллаж байна Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны А/297 тушаалаар “Нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний ангилал MNS 6457:2014” стандартыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан байгуулж, стандартын шинэчилсэн төслийг Стандартчилал хэмжил зүйн газрын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн Уул уурхай, ашигт малтмалын стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулаад байна.	90
5	4.2.13. Уул уурхайн түүхий эдийг боловсруулан, нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг байгаль орчинд ээлтэй, тогтвортой байх зарчмаар	2020 - 2050			Уул уурхайн түүхий эдийг боловсруулан, нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлыг хүрээнд дараах төслүүдийг хэрэгжүүлж байна. 1. “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэр: Ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, төслийн талбайд инженер геодезийн судалгаа, түгээмэл тархацтай ордын судалгааны ажлуудыг эхлүүлсэн бөгөөд төслийн гүйцэтгэл 12%-тай байна.	30

		<p>хөгжүүлж, хөрөнгө оруулалтын дэвшилтэт хэлбэрүүдийг дэмжинэ.</p>			<p>2. Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах төсөл: Засгийн газрын 2021.05.05-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах зориулалтаар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон. Уг тогтоолын 2 дахь хэсэгт исэлдсэн хүдрээс нуруулдан уусгах SX/EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хөрөнгөөр санхүүжүүлж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас “SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил” гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг 2021 онд зохион байгуулсан бөгөөд “Майнинг шорт лонг терм” ХХК-тай 2021.09.17-ны өдөр гэрээ байгуулсан. 2022 оны эхний хагас жилийн байдлаар Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд дараах ажлууд хийгдээд байна. Автозам: Зураг төслийн ажил 100% Төмөр зам: Зураг төслийн ажил 100% Усан хангамж, ариутгал татуургын систем: Зураг төслийн ажил 100% Цахилгаан хангамжийн ТЭЗҮ 100% “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь батлагдсан зураг төсөл хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу ҮТП-ийн дэд бүтцийг барьж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалт эхэлсэн. 2023 онд үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>3. Ган төмөрлөгийн үйлдвэр байгуулах төслүүд: “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн Монгол ган цогцолбор-1 төсөл, “Бэрэн групп” ХХК-ийн Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн төсөл, “Болдтөмөр ерөө гол” ХХК-ийн Алтанширээт аж үйлдвэрийн паркийн төслүүд хэрэгжиж байна.</p> <p>4. Газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолойн хамт: Технологийн бус барилга байгууламжийн ажил /EPC-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2022.6.01-ний өдрийн байдлаар 59,6%-тай байна. EPC-3 болон EPC-2 багц ажлын сонгон шалгаруулалт үргэлжилж байгаа бол лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /EPC-4/-ын лиценз</p>	
--	--	---	--	--	--	--

					эзэмшигчдийг шалгаруулсан, гүйцэтгэгчидтэй гэрээг байгуулаад байна.		
6		<p>4.2.14. Уул уурхайн ордыг ашиглалтад оруулж, өндөр технологийн хүнд үйлдвэрийн дараах цогцолборуудыг барьж, байгуулна. Үүнд: Уул уурхайн ордууд: Таван толгойн нүүрсний орд; Оюутолгойн далд уурхай; Дорноговийн цахиурын орд; Цагаан суваргын орд; Хармагтайн орд; Литийн орд; Газрын ховор элементийн хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлнэ. Хүнд үйлдвэр: Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр; Нефть-хими, кокс-хими, металлургийн үйлдвэр; Нүүрс угаах үйлдвэр; Нүүрс-хими, нүүрс-эрчим хүч, метан хийн үйлдвэрлэл, технологийн парк; Ган төмөрлөгийн үйлдвэр; Жонш баяжуулах үйлдвэр;</p>	2020 - 2050		<p>1. <i>Тавантолгойн нүүрсний орд:</i> “Эрдэнэс-Таван толгой” ХК нь Цанхийн зүүн хэсэгт 2010 оны 8 дугаар сарын 27 нд, Цанхийн баруун хэсэгт 2013 оны 2 дугаар сарын 16 нд уурхайн үйл ажиллагааг эхлүүлсэн. Тус компани 2010-2021 оны хугацаанд нийт 385.8 сая.м3 хөрс хуулж, 84.0 сая.тн нүүрс олборлож, 77.4 сая.тн нүүрс борлуулж, 4,081.5 сая ам долларын борлуулалтын орлоготой ажиллаж, улс, орон нутгийн төсөвт 2,627.7 тэрбум төгрөгийн татвар, хураамж төвлөрүүлсэн байна. “Эрдэнэс-Таван толгой” ХК нь Засгийн газрын холбогдох шийдвэрийн дагуу Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам, Тавантолгой түлш, Тавантолгой дулааны цахилгаан станц, Тавантолгойн нүүрс ачих байгууламж зэрэг үндэсний хэмжээний томоохон төслүүдэд санхүүжилтэд нийтдээ 3,340,753 сая төгрөг зарцуулсан байна. Нүүрс баяжуулах үйлдвэрийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, төслийн талбайд инженер геодизийн судалгаа, түгээмэл тархацтай ордын судалгааны ажлуудыг эхлүүлсэн бөгөөд төслийн гүйцэтгэл 12%-тай байна. Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 7 хувьд хүрсэн. Ачилтын нэгдсэн төвийн бүтээн байгуулалтын ажил 2022 оны 4 сард эхэлсэн бөгөөд ажлын гүйцэтгэл 21%-тай байна. Загийн усны хоолой усан хангамжийн төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн бөгөөд төслийн нийт гүйцэтгэл 26%-д хүрсэн.</p> <p>2. <i>Оюутолгойн далд уурхай:</i> УУХҮСайдын 2022.05.19-ний өдрийн А/113 тоот тушаалаар “Оюу толгой” ХХК-ийн далд уурхайн бүтээн байгуулалттай газар дээр нь үзэж танилцаж, далд уурхайг ашиглалтад хүлээн авах эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Комиссын бүрэлдэхүүнийг баталсан. Дээрх тушаалын дагуу УУХҮЯ, ЭХЯ, БОАЖЯ, МХЕГ, АМГТГ, ОБЕГ, Өмнөговь аймгийн засаг даргын тамгийн газар, “Оюу толгой” ХХК, “Эрдэнэс оюу толгой” ХХК-ийн төлөөлөл оролцсон комисс 2022 оны 5-р сарын 25-ний өдөр Оюу толгойн далд уурхайд ажиллаж, далд уурхайн бүтээн байгуулалт гүйцэтгэлтэй танилцаж, далд уурхайг хүлээж авах хүртэл, хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмж өгч ажилласан. 2021 оноос 2022 оны 6-р сар хүртэл 800.5 сая ам.доллар хөрөнгө далд</p>		50

		<p>Алт цэвэршүүлэх үйлдвэрийг тус тус барьж байгуулна.</p>			<p>уурхайн бүтээн байгуулалтад зарцуулсан. 2022 онд 1257.3 сая ам.доллар зарцуулахаар төлөвлөсөн. Оюу толгой төслийн далд уурхай ашиглалтад орсноор жилд 40.0 сая тн хүдэр олборлож, 1,553.0 мян.тн зэсийн баяжмал үйлдвэрлэнэ. Зэсийн баяжмал дахь зэс 436.0 мян.тн, алт 502.0 мян.унц, мөнгө 3495.0 мян.унцад хүрнэ. Оюу толгой төслийн далд уурхай ашиглалтад орсноор зэсийн баяжмал үйлдвэрлэл 622 мян.тн-оос 1553 мян.тн болж 2.4 дахин өссөнөөр Монгол Улсын экспортын орлого 26.62 хувиар нэмэгдэнэ. 2022 оны хагас жилийн байдлаар Оюу толгойн далд уурхайн төслийн барилгын ажлын гүйцэтгэл-90%, материал зөөвөрлөх системийн гүйцэтгэл-90%, далд уурхайн бүтээн байгуулалт 83.7%-д хүрсэн.</p> <p><i>3. Цагаан суваргын орд:</i> Цагаан суваргын зэс, молибдений ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулж өнгөрсөн онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх зорилгоор уулзалт хэлэлцээрүүд хийгдэж байна. Өнөөдрийн байдлаар бүтээн байгуулалтын ажил 69%-тай. Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулгын ажлыг 2023 онд хийж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Төслийн талбайд 2022 онд барилга угсралтын ажил хийгдээгүй. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 1 дүгээр албан даалгаварт тусгагдсан Цагаан суваргын зэс, молибдений төслийг эрчимжүүлэх арга хэмжээний талаар танилцуулга бэлтгэн Засгийн газрын 2022.04.20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулсан. Монгол Улсын засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 24 дүгээр тэмдэглэлийн 1-д Цагаан суваргын зэс, молибдений ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд тоног төхөөрөмж суурилуулалт, барилгын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай гадаадаас ажиллах хүч, мэргэжилтнийг авах талаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн арга хэмжээ авч ажиллахыг УУХҮЯ, ХНХ-ийн сайд нарт даалгасан. УУХҮЯ сайд тус төслийн бүтээн байгуулалтай газар дээр очиж танилцсан.</p> <p><i>4. Хармагтайн орд</i> Хармагтайн алт-зэсийн орд нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших ба Улаанбаатар хотоос урд зүгт 490 км зайд, Оюу толгой уулын баяжуулах үйлдвэрээс зүүн хойд зүгт 120 км зайд, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн уурхайгаас зүүн хойд зүгт 73</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>км зайд, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвөөс зүүн хойш ойролцоогоор 60 км зайд тус тус байрлана.</p> <p>Хармагтайн MV-017387 тоот ашиглалтын тусгай тусгай зөвшөөрөлтэй 6647 га талбайг Занаду Майнз Компанийн охин компани болох Оюут-Улаан ХХК эзэмшдэг.</p> <p>2010 онд (А+В+С) зэрэглэлээр 86,567,105.0 тн хүдрийн, 38.4 тн алт, 348,000.0 тн зэсийн нөөцийг Улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Нэмэлт хайгуулын ажлын үр дүнд ордын нөөцийг дахин тооцоолж 2018 онд ордын нийт баттай, бодитой, боломжтой (А+В+С) зэрэглэлээр хүдрийн нөөцийг 111,926,218.0 тн, алт 51,9 тн, зэс 512,904.0 тн, мөнгө 129,6 тн гэж шинэчилэн тооцсон.</p> <p>Ордын Ил уурхайгаар ашиглах боломжтой 56,400,821.0 тн хүдэрт 23,1тн алт, 223,727.0 тн зэс, 48,0тн мөнгө, Далд уурхайгаар ашиглах боломжтой 35,592,693.0 тн хүдэрт 22,6 тн алт, 214,836.0 тн зэс, 67,4тн мөнгө гэж тооцсон.</p> <p>5. Литийн ордын төсөл:</p> <p>Тусгай зөвшөөрөл: MV-017303, XV-012685, Талбайн хэмжээ: 4720.16 га, 12410.94 га, ТЗ эзэмшигч: "Алкали металлы Монголиа" ХХК, Хөх дэл нэртэй талбай,</p> <p>Ордын байршил: Засаг захиргааны хувьд Дундговь аймгийн Өлзийт сумын 1-р багийн нутагт харъяалагдах бөгөөд Улаанбаатар хотоос зүүн-урагш 550 км зайд, Мандалговь хотоос зүүн-урагш 98 км-т оршино. Тусгай зөвшөөрлийн газар зүйн солбицол нь: Хойд өргөрөгийн 45° 06' 11.56" - 45° 11' 41.57" , Зүүн уртрагийн 106° 47' 1.41" -106° 59' 51.42"</p> <p>Хөхдэлийн хуучнаар 12685Х /MV-017303/ тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд 2009-2011 онд хайгуул хийж литийн хүдрийн нөөц баттай, бодитой болон боломжтой (А+В+С) нөөцийг 278.76 сая.тн-оор, литийн нөөцийг 435.48 мян.тн-оор тогтоосон.</p> <p>Хөх дэл нэртэй үлдсэн хайгуулын XV-012685 тоот тусгай зөвшөөрлийн талбайд 2012-2020 онд Хөх дэлийн ордын зүүн хойд болон баруун хэсгүүдэд 2012-2020 онд хайгуулын ажил гүйцэтгэж нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр литийн нөөцийг 831,747.0 тн-оор тогтоосон.</p> <p>6. Газрын ховор элемент:</p> <p>2022 онд үргэлжлэн хэрэгжүүлэх өндөр технологийн түүхий эд /газрын ховор элемент/-ийн ӨТТЭ-1-2021 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлан ажлыг эхлүүлсэн. Төслийн 2022 оны хээрийн болон суурин</p>
--	--	--	--	--	--

					<p>боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн 2022.04.20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн.</p> <p>Шинээр хэрэгжүүлж эхлэх өндөр технологийн түүхий эд газрын ховор элемент/-ийн /ӨТТЭ-2-2022/-ны төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн дэд сайд баталсан.</p> <p>ӨТТЭ-2-2022 төслийн гүйцэтгэгчийг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу зохион байгуулж хамгийн сайн оролцогчоор шалгарсан хуулийн этгээдтэй зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.06.10-ны өдөр байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн.</p> <p>7. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төслүүд:</p> <p>1. Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл:</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/103 дугаар тушаалаар "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын түшиглэн байгуулах үйлдвэрлэл, технологийн паркийн "Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл"-д шүүмж дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчийн хэсэг байгуулагдан ажилласан бөгөөд Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар ТЭЗҮ-ийг хүлээн аваад байна.</p> <p>2. Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах SX-EW технологиор боловсруулах катодын зэсийн үйлдвэр байгуулах төсөл:</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/91 дугаар тушаалаар "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Эрдэнэтийн овоо зэс молибдены ордын исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах SX-EW технологиор жилд 10.0 мянган тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд шүүмж дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчийн хэсэг байгуулагдан ажилласан бөгөөд Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар ТЭЗҮ-ийг хүлээн аваад байна.</p> <p>8. Ган төмөрлөгийн үйлдвэр байгуулах төслүүд:</p> <p>1. Монгол ган цогцолбор-1:</p> <p>Эдийн Засаг, Хөгжлийн Яам /хуучнаар/, "Кью Эс Си" ХХК-ийн хооронд 2014 онд байгуулсан "Уул уурхай, металлургийн</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>цогцолбор байгуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх "Концессын гэрээ"-г ЗГ-ын 2022.04.13-ны өдрийн 148 дугаар тогтоолоор цуцалсан. Гэрээ цуцлах хүртэлх хугацаанд дараах ажлууд хийгдсэн. Үүнд:</p> <p>1) Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Ерөө дэд станцын өргөтгөл, Төмөртэйн ордыг цахилгаан эрчим хүчээр хангах 110 кВ-ын 50 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 16 МВА чадалтай Төмөртэйн дэд станцыг барьж байгуулан улсын комисст хүлээлгэн өгч, бүрэн ашиглалтанд оруулсан (2012-2014 он)</p> <p>2) Төмөртэйн уурхайд 750 тн/цаг хүчин чадалтай хуурай соронзон баяжуулах үйлдвэрийг угсарч, бүрэн ашиглалтанд оруулсан (2014 он)</p> <p>3) Төмөртэйн уурхайн Зүүний зүүн биет дээр ил уурхайн бэлтгэл ажлыг хангаж, уурхайд шаардлагатай машин механизм, техник хэрэгсэл худалдан авч, Зүүний зүүн уурхайг 2014 онд шинээр нээн, хөрс хуулалтыг эхлүүлсэн.</p> <p>4) Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн өөрийн 45 МВА Төмөрлөг дэд станцыг 10 МВА дэд станцаар өргөтгөх ажлыг хийж дуусгасан (2013-2014 он)</p> <p>5) Сэлэнгэ аймгийн Ерөө суманд орших Хандгайт өртөөн дэх жилд 2.5 сая тн төмрийн хүдрийн баяжмал ачиж тээвэрлэх Хандгайт терминалыг байгуулж ашиглалтанд оруулсан (2014 он)</p> <p>6) Жилд 1 сая тн хүдэр боловсруулж, 700 мян.тн нойтон баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай Нойтон соронзон баяжуулах үйлдвэрийг хаягдлын байгууламжийн хамт ашиглалтанд оруулж, улсын комисст хүлээлгэн өгсөн (2013-2014 он)</p> <p>7) Дарханы Төмөрлөгийн үйлдвэр дээр жилд 2 сая тн баяжмал ачих хүчин чадалтай төмөр замын терминалыг барьж ашиглалтанд оруулсан (2014 он)</p> <p>8) Төмөртолгойн уурхайд 500 тн/цаг хүчин чадалтай 2 дахь хуурай соронзон баяжуулах үйлдвэрийг угсарч дуусган, улсын комисст хүлээлгэн өгсөн (2014 он)</p> <p>9) 2015 оны 12 сард Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Хандгайт өртөө чиглэлийн төмөр зам, жилд 2.5-8 сая тн төмрийн хүдрийн баяжмал ачиж тээвэрлэх Төмөртэйн терминал, иж бүрэн өртөөний бүтээн байгуулалтын ажлыг дуусгаж, улсын комисст хүлээлгэн өгсөн (2014-2015 он)</p> <p>10) "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК /хуучин нэрээр/ евро стандартад нийцсэн давтах аргын ган бөмбөлгийн үйлдвэрийг 2017 оны 1 сарын 28-нд ашиглалтанд оруулсан (2016-2017 он)</p> <p>11) Сэлэнгэ аймгийн Дулаанхаан өртөөнөөс Хүдэр сум хүртэл 104.5 километр хатуу хучилттай авто замыг хувийн хэвшлийн</p>
--	--	--	--	--	---

					<p>хөрөнгө оруулалттай концессын гэрээгээр "Дарханы төмөрлөгийн үйлдвэр", "Peak Development" компани барьж 2017 оны 6 дугаар сарын 23-ны өдөр нээлтээ хийсэн. (2015-2017 он)</p> <p>12) Төмөрлөг дэд станцын хүчин чадлыг 6МВА чадлаар нэмэх өргөтгөлийн ажлыг 2017 оны 8 сард эхлүүлсэн бөгөөд 2018 оны 01 сард ашиглалтанд оруулсан. (2017-2018 он)</p> <p>13) 8-10 тн/цаг хүчин чадалтай пресс хайч суурилуулах ажлыг 2017 оны 10 дугаар сард эхлүүлсэн бөгөөд 2018 оны 1 сард ашиглалтанд оруулсан. (2017-2018 он)</p> <p>14) Хэлбэлзүүлэгч ширээ, цахилгаан соронзон холигч, зэс талсжуулагч шинээр суурилуулах төслийг хэрэгжүүлж 2019 оны 4 дүгээр сард ашиглалтанд оруулсан.</p> <p>15) Хаягдал төмөр боловсруулалтыг сайжруулах, 30 тн/цаг хүчин чадалтай булт шреддерийн шугам суурилуулах төсөл (2020-2021 он)</p> <p>16) Жилд 350 мян.тн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай "Монгол ган цогцолбор 1" төслийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын "MCC-CERI", Монгол улсын "Кью Эм Си" ХХК-иар гүйцэтгүүлж, ЭБМЗ-ийн 2021.09.30-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж, хүлээж авсан.</p> <p>2. Алтанширээт аж үйлдвэрийн парк: "Алтанширээт аж үйлдвэрийн парк"-ийн 2022 онд төлөвлөсөн бүтээн байгуулалтын ажлуудын явц:</p> <ul style="list-style-type: none"> - Дэд бүтцийг бий болгох хүрээнд 12 км төмөр зам, 6.3 МВт-ын цахилгааны дэд станц, 110 кВ, 10 кВ-ын 9,4 км цахилгаан дамжуулах агаарын шугам барьж байгуулсан. - 2021 онд 2 сая.тн/жил хүчин чадалтай төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэрийг барьж байгуулсан. - Нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулж, ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр ирүүлсэн. - Нүүрс баяжуулах үйлдвэрийн суурь, барилгын ажил, тоног төхөөрөмжийн татан авалт, суурилуулах ажил хийгдэж байна. - Паркийн ус хангамжийг шийдэх зорилгоор Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших "Бор хөөвөр"-ийн газрын доорх усны ордоос ус цуглуулах байгууламж барих ажил, ажилчдын 5 блок байр барих, нүүрс ачиж, буулгах талбайн газар шорооны ажлыг 2022 оны 5 дугаар сард тус тус эхлүүлээд байна. - 2022.03.02-ны өдрийн ЗГ-ын хуралдаанд "Алтанширээт аж үйлдвэрийн парк"-ийн төслийн бүтээн байгуулалтын явц болон
--	--	--	--	--	---

					<p>цаашид хийгдэх ажил, тулгамдаж байгаа асуудлын талаар УУХҮ-ийн сайд танилцуулсан.</p> <p>- "Монголын эдийн засгийн чуулган 2022" арга хэмжээний хүрээнд 2022.03.24-ний өдөр "Алтанширээт аж үйлдвэрийн парк"-ийн зарим үйлдвэрийг түүхий эд /коксжих нүүрс/-ээр тогтвортой хангах боломж бүрдүүлэх зорилгоор "Эрдэнэс Тавантолгой" ХК болон "Болдтөмөр Ерөө гол" ХХК-ийн хооронд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.</p> <p>3. Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэр: "Бэрэн групп" ХХК нь Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2014 онд 22.7 сая ам.доллар, 2018 онд 4.5 сая ам.доллар, нийт 27.2 сая ам.долларын зээлийн санхүүжилт авсан ба үйлдвэр ашиглалтад орж үйл ажиллагаа эхлээгүйн улмаас уг зээл эргэн төлөгдөөгүй байна. Цаашид үйлдвэрийг ашиглалтанд оруулахад шаардагдах 30.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмж олгох хүсэлтийг тус компаниас Хөгжлийн банк болон УУХҮЯ-нд гаргасан. Үүний дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Монгол Улсын хөгжлийн банкны хооронд "Төмөрлөг боловсруулах үйлдвэрийн төслийн бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн болон технологийн өдөр тутмын хяналтыг хийх зорилго бүхий "Хамтран ажиллах санамж бичиг"-ийг 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдөр (DBM/01/64 дугаар) байгуулсан.</p> <p>"Хамтран ажиллах санамж бичиг"-ийн хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр Хөгжлийн банктай уулзалт зохион байгуулж, "Бэрэн групп" ХХК-ийн зээл, өр төлбөр, төслийн ажлыг эрчимжүүлэх, шаардлагатай нэмэлт санхүүжилт /зээл/-ийн асуудлаар боломжит хувилбаруудыг ярилцсан. 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар "Бэрэн групп" ХХК-ийн төслийг өр, зээл, нэмэлт зээлийн асуудлаар Хөгжлийн банк дээр хийж байгаа тооцоо судалгааны ажил эцэслэн шийдэгдээгүй хүлээгдэж байна.</p> <p>9. Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэр байгуулах: БНКазУ-ын "Сымбат инженеринг" компанийн боловсруулсан үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ, төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/100 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд ажлын хэсгийн дүгнэлтийг 2021.12.09-ний өдөр ирүүлсэн. Үүний дагуу төслийг хэрэгжүүлэх чиглэлээр 2022 онд гүйцэтгэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг ЗГ-ын 2020-2024 оны үйл</p>
--	--	--	--	--	---

					ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.7.7 дахь хэсэгт заагдсан арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан гаргаж, баталгаажуулах, үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх болон төсөл хэрэгжүүлэгчийг нээлттэй сонгон шалгаруулах ажлыг 2022 оны I улиралд багтаан зохион байгуулахаар тус төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг ханган талаар УУХҮ-ийн сайдын 2022.01.06-ны өдрийн 01/43 дугаартай албан бичгийг “Эрдэнэс Монгол” ХХК-д хүргүүлсэн. Мөн үйлдвэрийг барьж байгуулах олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын ажлын даалгавар боловсруулах ажлын хэсгийг “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн захирлын тушаалаар байгуулан ажиллаж байна. Ажлын даалгавар боловсруулах ажлын хэрэгжилт 90 хувьтай.	
7		4.2.15. Говийн бүс рүү ус дамжуулах хоолой барьж байгуулна.	2020 - 2050		Улсын Их Хурлын чуулганы 2020.08.28-ны өдрийн хуралдаанаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна”, “Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ” гэсэн зорилтууд тусгагдсан. Үүнтэй холбоотойгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК нь нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станц болон бусад дэд бүтцийн төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулж байна. Улсын Их Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт барихаар төлөвлөж байгаа Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрт олгосон 220 л/сек усны зөвшөөрлийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д шилжүүлж өгөхийг хүссэн хүсэлтийг 2020.10.08-ны өдрийн 03/2510 дугаар албан бичгээр Байгаль орчин аялал, жуулчлалын яаманд хүргүүлсэн. Тавантолгойн нүүрсний ордод түшиглэн байгуулагдах төслүүдийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр БОАЖЯ-ны байр суурийг сонсох, харилцан мэдээлэл, санал солилцож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох уулзалтыг УУХҮСайд Г.Ёндон, Усны газрын дарга Ш.Мягмар, “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг, Дэлхийн банкны “2030 Усны нөөцийн бүлэг”-ийн Монгол дахь суурин төлөөлөгч Д.Доржсүрэн болон бусад холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан 2021.04.03-ны өдөр зохион байгуулсан. Мөн тус яамнаас Тавантолгойн ордыг түшиглэн баригдах төслүүдийн усан	30

					<p>хангамжийн асуудлын талаар танилцуулга бэлтгэж, Засгийн газрын 2022.01.26-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулж, хуралдааны 6 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. “Эрдэнэс Тавантолгой” ХК говийн бүсэд ус дамжуулах хоолой баригдах хүртэл хугацаанд Загийн усны хоолойг ашиглахаар холбогдох зөвшөөрлүүдийг авсан. Өнөөгийн байдлаар төслийн шугам хоолой болон цахилгаан дамжуулах агаарын шугамын трассын дагуу, мөн усан сангуудын байршлын дагуу улаан шугам, тэг тэнхлэг байгуулсан. Төслийн талбайд ажиллах ажилчдын кемп байгуулсан. Арматур, анкер тулгуурын төмөр бетон суурь, ЦДАШ-н бетон дундын тулгуур, хайрга дайрга зэрэг материалуудын 70 орчин хувь нь төслийн талбайд хүргэгдсэн. Импортоор орж ирэх бараа материалын 93% захиалга өгөн, гэрээ хийгдсэн. Ажлын талбайд машин механизм, техник тоног төхөөрөмжийн 70% нь байрлан ажиллаж байна. Барилга угсралтыг ажил / Гүний худаг, шугам хоолой, усан сан/ 5% гүйцэтгэлтэй буюу нийт төслийн гүйцэтгэл 27%-тай байна. Төслийн талбайд нийт 92 хүн ажиллаж байна. Цагаав цавын гүний усны ордоос ус татах төслийн хувьд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас 220 л/с ус ашиглуулах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулсан бөгөөд дараагийн шатны зөвшөөрлийг гаргуулахаар ажиллаж байна. Төслийн гүйцэтгэл 26 хувьд хүрсэн.</p>	
8	4.2.16. Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химийн үйлдвэр барьж байгуулна.	2020 - 2050		<p>Технологийн бус барилга байгууламжийн ажил /ЕРС-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2022.6.01-ний өдрийн байдлаар 59,6%-тай байна. ЕРС-3 багц ажлын тендерийн материалд холбогдох өөрчлөлтийг оруулан 2022.4.20-ны өдөр “Тендерийн өмнөх уулзалт”-ыг зохион байгуулж, “Түргэвчилсэн тендер”-ийг 2022.5.04-нд зарлаж, эхний компаниуд Монголд ирж ажиллах нөхцөл, хууль эрх зүйн орчин, техник, тоног төхөөрөмж, бараа материал нийлүүлэх боломж, ажиллах хүчний байдалтай танилцаж эхлээд байна. ЕРС-2 багц ажлын “Тендерийн өмнөх уулзалт”-ыг 5 сарын 17-нд зохион байгуулж 2022.6.06-ны өдөр тендерийг зарласан. Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /ЕРС-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулсан, Устөрөгчийн байгууламжийн лиценз эзэмшигч Итали улсын Кинетикс техноложи компанитай, Хүхэр ялгах байгууламжийн лиценз эзэмшигч Франц улсын Аксенс компани, Бензин боловсруулах, Гидрокрекинг, Дизелийн гидроцэвэрлэгээ, Дизелийн гидроцэвэрлэгээ, Шингэрүүлсэн шатдаг хий ялгах байгууламжуудын лиценз эзэмшигч АНУ-ын ЮүӨүПи Хонивэлл компанитай тус тус гэрээг байгуулаад байна.</p>	50	

9		4.2.17. Гадаад, дотоод зах зээлд чиглэсэн гүн боловсруулалтын технологид суурилсан хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2020 - 2050		<p>ЗГ-ын 2022.03.16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр даалгасны дагуу “Аж үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө (үйлдвэр тус бүрээр эдийн засгийн үр өгөөжийг харуулсан)-г дахин нарийвчлан боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар УУХҮ-ийн сайдын 2022.05.24-ний өдрийн 01/1500 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>Мөн УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд “Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор үйлдвэрлэл, технологийн парк”, Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр” болон “Исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл”, Оюутолгойн ордыг түшиглэн “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл”, Дархан-Уул аймагт “Монгол ган цогцолбор–1” төсөл, “Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэр”, “Алтанширээт аж үйлдвэрийн парк” гэх зэрэг Хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт техник, технологи, инновацид суурилсан нэмүү өртөг шингэсэн, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, дотоодын бүтээн байгуулалтын хэрэгцээг хангаж, шинээр ажлын байр бий болгох мега төслүүдийг ШСБ-ын хөгжлийн төслүүдийн жагсаалтад оруулж, төслийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан төслийн хэрэгжилт, явцын талаар 7 хоног бүр төсөл хэрэгжүүлэгчээс тайлан авч, ЭЗХЯ-нд хүргүүлэн ажиллаж байна.</p>	30
10		4.2.18. Боловсруулах салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэлхийн брэндийн түвшинд хөгжүүлнэ.	2020 - 2050		<p>Нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлыг хүрээнд дараах төслүүдийг хэрэгжүүлж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэр 2. Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах 3. Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах 4. Катодын зэс үйлдвэрлэх төсөл 5. Монгол ган цогцолбор-1 төсөл 6. Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн төсөл 7. Алтанширээт аж үйлдвэрийн парк 8. Газрын тос боловсруулах үйлдвэр <p>Эдгээр төслүүд хэрэгжсэнээр боловсруулах салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспорт нэмэгдэж дотоодын бүтээн байгуулалтын хэрэгцээг хангана.</p>	50

11		<p>4.2.24. Геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.</p>	<p>2020 - 2050</p>	<p>Батлагдсан: 27,746.7 Гүйцэтгэл: 4,661.2 Санхүүжилт: 4,661.2</p>	<p>- 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн Сүүжийн говь-50, Шүтээн улаан уул-50, Норовлин-50, Чулуун хороот-50 төслүүдийн үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар 2022 оны 6-р сарын 02-нд хэлэлцэж хүлээн авсан. Ингэснээр 17,787.84 км2 талбай буюу 1.13%, нийтдээ 43.1%-ийг, Монгол орны нутаг дэвсгэрийн 14.1%-ийг хамарсан К хавтгайн хэмжээнд Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх УГЗ-200-К-нэгтгэл төслийн үр дүнгийн тайлантай танилцан ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮС-ын 2022 оны А/03 дугаар тушаалаар хүлээн авсан бол L хавтгайн (53.66%) хэмжээнд хээрийн судалгааны ажлыг бүрэн дуусгаснаар нутаг дэвсгэрийн 67.76%-ийг хээрийн судалгаанд тус судалгааны ажилд хамруулсан. 104,044.0 кв.км буюу нутаг дэвсгэрийн 6.6%-д агаарын геофизикийн хэмжилт хийх нислэгийг дуусгасан. Нислэгийн ажлыг дуусгаснаар нутаг дэвсгэрийн 66%-ийг судалгаанд хамруулсан бол 2019-2021 онд нутаг дэвсгэрийн үлдсэн 1,062,197.0 км2 буюу 67.9%-д хээрийн судалгаанд хамруулж дуусгасан. Ингэснээр Монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд буюу 100%-д хээрийн судалгааны ажилд бүрэн хамруулсан. Монгол орны баруун, баруун өмнөд хэсгийн алтны хэтийн төлөвийг үнэлэх БӨМ-Алт-2019 төсөл, 2021 оноос хэрэгжиж байгаа Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан Мезозой, Кайнозойн насны хурдас чулуулгийн тархалт, тогтоц, түүнтэй холбоотой үүсэн ашигт малтмалын минерагений судалгааны Мезо-Кайнозой-2021 болон 2022 оноос шинээр хэрэгжүүлэх Монгол Улсын босоо тэнхлэгийн дагуух нутгийг хамарсан геологийн орчин, тогтоцын судалгааны Геологийн орчин-2022, Баруун Монголын шатах ашигт малтмалын хэтийн төлөвийг тогтоох БМШАМ-2022, Монгол орны алтны металлогенийн зураг зохиох Мета-алт-500 төслийг шинээр хэрэгжүүлэхээр төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн дэд сайд батлуулж судалгааны ажлыг эхлүүлсэн. Эрэл үнэлгээ-1-2020, Эрэл үнэлгээ-2-2021, Эрэл үнэлгээ-3-2021, Эрэл үнэлгээ-4-2022 төслийн 2022 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлуулж, 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-өөр хэлэлцэн шийдвэрлэж судалгааны ажлыг эхлүүлээд байна.</p>	90
----	--	---	--------------------	--	---	----

					<p>-2022 оны эхний хагас жилийн байдлаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг 141,979 га талбайд зарласнаар 121,503 га талбайд 50 тусгай зөвшөөрлийг олгож улсын төсөвт 13.9 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна.</p> <p>-Ашигт малтмалын хайгуулын ажлын 50 тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн алт /үндсэн/ 1,004.39 мян.тн/кг металлаар, алт /шороо/ 559.42 кг металлаар, зэс 10,702.9 мян.тн/тн металлаар, төмөр 40,488.25 мян.тн хүдрээр, хайлуур жонш 1,095.77 мян.тн хүдрээр, нүүрс 16.26 сая тн, шохойн чулуу 50,516.54 мян.тн, дайрга 24.1 сая м3, боржин 8,294.67 мян.м3, кварц 1,855.19 мян.тн, гантиг 423.51 мян.м3, элсэн чулуу 7,991.19 мян.м3, элс 4,359.92 мян.м3, шавар 5,736.63 мян.м3, элс-хайрга 3,333.92 мян.м3-ийг улсын нэгдсэн санд бүртгэн нөөцийг өсгөсөн.</p>	
12	4.4. Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө.	4.4.12. Дотоодын боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг гадаад өрсөлдөөнөөс хамгаалах бодлого зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	2020 - 2050		<p>Засгийн газраас боловсруулсан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүн С.Бямбацогт нарын санаачилсан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй нэгтгэн, төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тайланг хийж гүйцэтгэн, хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хуулийн үзэл баримтлалыг батлуулсан. Мөн УИХ-ын чуулганы 2022.04.14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэхийг дэмжиж, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн. Ажлын хэсэг төмөрлөгийн үйлдвэр, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркуудын эдийн засаг, нийгэмд үзүүлэх голлох нөлөөллийг гаргаж, танилцуулга нэмэлтээр бэлтгэн боловсруулж, хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022.06.15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж, УИХ-ын чуулганы анхны хэлэлцүүлгийг 2022.06.30-ны хийж зарчмын зөрүүтэй 71 саналын томъёоллоор санал хурааж дараагийн хэлэлцүүлэгт бэлтгээд байна.</p> <p>Хүнд үйлдвэрийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т заасны дагуу Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж, 2021.11.24-ний өдөр УИХ-д өргөн</p>	30

					<p>мэдүүлсэн бөгөөд Үйлдвэржилтийн бодлогын байнгийн хорооны 2021.12.14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлээд байна.</p> <p>УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн холбогдох судалгааг хийх, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан.</p> <p>Ажлын хэсгийн зүгээс Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу "хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх аргачлал", хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл болон хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэргийг эцэслэн боловсруулсан.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөлд мэргэжлийн холбоод болон аж ахуйн нэгж байгууллагаас санал авах хэлэлцүүлгийг зохион байгуулж холбогдох саналын авч ажиллаж байна.</p>	
13	4.6. Эдийн засгийн төрөлжилт, инновац, шинэ технологи, хүний хөгжил, ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих чадавхтай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг бий болгоно.	4.6.1. Үндэсний баялгийн сангийн эрх зүйн орчныг төгөлдөржүүлж, зохион байгуулалтын шинэчлэлт хийнэ.	2020 - 2050		<p>Тус яамнаас МУ-ын Үндсэн хуулийн 6.2-д заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг хийсэн. Тус, хуулийн төсөлд бүх яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийн зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүй асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Монгол Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн хуульд заасны дагуу ХЗДХЯ болон СЯ-наас 2022-06-17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.</p>	70
14		4.6.2. Баялгийн сангийн засаглалын зохистой зарчмуудыг тодорхойлж, холбогдох дүрэм, журмыг батлуулна.	2020 - 2050		<p>Үндэсний баялгийн сангийн тухай болон Хөгжлийн сангийн тухай хууль УИХ-аар батлагдсаны дараа холбогдох дүрэм, журмыг батлуулах ажлыг зохион байгуулна.</p>	Хугацаа болоогүй
15		4.6.3. Баялгийн сангийн тухай хуульд	2020 - 2050		<p>Үндэсний баялгийн сангийн тухай болон Хөгжлийн сангийн тухай хууль УИХ-аар батлагдсаны дараа хэрэгжинэ.</p>	Хугацаа болоогүй

	заасан орлогын эх үүсвэрээс санд хөрөнгө төвлөрүүлж, хуульд заасан арга хэлбэрээр хөрөнгийг арвижуулна.					
16	4.6.4. Сангийн тухайн жилийн нийт хөрөнгийн зарим хэсгийг олон улсын санхүүгийн зах зээл дээр зээлжих зэрэглэл нь "АА" болон түүнтэй адилтгах үнэлгээтэй, өгөөж нь тодорхой санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийж эхэлнэ.	2020 - 2050			Үндэсний баялгийн сангийн тухай болон Хөгжлийн сангийн тухай хууль УИХ-аар батлагдсаны дараа хэрэгжинэ.	Хугацаа болоогүй
17	4.6.5. Сангийн хөрөнгөөс том хэмжээний төсөлд, эсхүл эдийн засгийн төрөлжилтийг хангах, иргэдийн аюулгүй байдал, тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн төсөлд хөрөнгө оруулалт хийж эхэлнэ.	2020 - 2050			Үндэсний баялгийн сангийн тухай болон Хөгжлийн сангийн тухай хууль УИХ-аар батлагдсаны дараа хэрэгжинэ.	Хугацаа болоогүй
18	4.6.7. Иргэдийн аюулгүй байдал, тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгмийн хөгжлийг дэмжих төслүүдэд хөрөнгө оруулалт хийнэ.	2020 - 2050			Үндэсний баялгийн сангийн тухай болон Хөгжлийн сангийн тухай хууль УИХ-аар батлагдсаны дараа хэрэгжинэ.	Хугацаа болоогүй
19	4.6.10. Мэдлэгийн эдийн засгийг дэмжих зорилго бүхий хөрөнгө оруулалтын шинэ	2020 - 2050			Үндэсний баялгийн сангийн тухай болон Хөгжлийн сангийн тухай хууль УИХ-аар батлагдсаны дараа хэрэгжинэ.	Хугацаа болоогүй

		хэлбэрүүдийг нэвтрүүлнэ.					
20		4.6.11. Монгол Улсын иргэдэд давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг хүртээнэ.	2020 - 2050			"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөл 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 09 дүгээр тогтоолыг баталж, компанийн 2019 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 90 /ерэн/ төгрөгийн ногдол ашгийг 1072 хувьцаа эзэмшигч 2.5 сая иргэдэд оглох ажлыг 2020 онд зохион байгуулсан. Улсын Их Хурлын чуулганы 2020 оны 01 сарын 10 өдрийн хуралдаанаар Иргэдийн тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг баталсан. Иргэдийн тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль батлагдсанаар Төрийн өмчит "Эрдэнэс Монгол" ХХК өөрийн охин компанийн эзэмшлийн Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогоос төрд ногдох өгөөжийг барьцаалан үнэт цаас гаргах замаар иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн тодорхой хэсгийг төлөх боломж бүрдэхийн зэрэгцээ зээл аваагүй 194 мянган иргэнд Салхитын мөнгөний ордын орлогоос нэг сая төгрөгийн үнэт цаас олгох боломж бүрдсэн.	100
	ДҮН						56.43

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР
“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ
БИЧГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2022 оны эхний хагас жилийн байдлаар/**

2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилго, зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүй

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

УУХҮЯ-ны хэрэгжүүлэх 3 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 2022 оны хагас жилийн биелэлт **73.3** %-тай дүгнэгдэв.

Шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг авч үзвэл:

- Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь шалгуур үзүүлэлтийн биелэлт **100.0** хувьтай.
- Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь шалгуур үзүүлэлтийн биелэлт **90.0** хувьтай.
- Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь шалгуур үзүүлэлтийн биелэлт **30.0** хувьтай дүгнэгдлээ.

2022 оны хагас жилийн байдлаар хэрэгжилт хангалтгүй зорилтот түвшиндээ хүрээгүй, боловсруулалтын шатанд байгаа 1 шалгуур үзүүлэлт байна. Үүнд:

- Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь.

Дөрөв. Дүгнэлт

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 73.3 хувиар үнэлэгдэв.
2. Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн үнэлгээгээр 2022 оны эхний хагас жилийн байдлаар “бүрэн хэрэгжсэн” холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан 2 /90%, 100%/, хэрэгжилт хангалтгүй 1 /30%/, шалгуур үзүүлэлт байна.

Тав. Санал, зөвлөмж

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинг жил бүрээр нарийвчлан гаргаж, хэрэгжилтийг тайлагнаж байх
2. Бодлогын баримт бичгийн хэрэгжилттэй шалгуур үзүүлэлтийн тайланг хамт тайлагнаж байх


Хянасан:

ХШҮДАГ-ын дарга

 Ц.Одхүү

Танилцуулга боловсруулсан:

ХШҮДАГ-ын ахлах шинжээч

 Х.Цэнд-Аюуш /2022.06.30/

“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

2022 оны 06 дугаар сарын 30

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээллийн эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах арга зүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хэрэгжилт	Үнэлгээ
				2025	2030	2050						
ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ												
35	Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	24.3	30.6	31.4	25.3	Эдийн засгийн салбаруудын хөгжлийн түвшинг ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ	Үндэсний статистикийн хороо, Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Уул уурхайн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 26% /2022 оны эхний 5 сарын байдлаар/, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 65% /2022 оны эхний 5 сарын байдлаар/, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 64% /2022 оны 1 дүгээр улирлын байдлаар/, нийт экспортын 94% /2022 оны эхний 5 сарын байдлаар/, Улсын төсвийн 23% /2022 оны эхний 5 сарын байдлаар/-ийг тус тус бүрдүүлж байна. Уул уурхайн салбарын орлого зэсийн баяжмал, нүүрс, алт, төмрийн хүдэр зэрэг голлох ашигт малтмалаас төвлөрч байна. Дээрх дөрвөн голлох нэр төрлийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 95%-г бүрдүүлж байна. Засгийн газрын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөр, “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт 2025 онд уул уурхайн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 30.6%-д хүргэхээр төлөвлөсөн. Нүүрс экспортыг 2021 онд 36.0 сая тн, 2022 онд 38 сая тн-д, 2023 онд	100

											40 сая тн-д, 2024 онд 42.5 сая тн-д, зэсийн баяжмалын экспортыг 2021 онд 1430.0 мян.тн-д, 2022 онд 1673.3 мян.тн-д, 2023 онд 2188.5 мян.тн-д, 2024 онд 2469.5 мян.тн-д, төмрийн хүдэр, баяжмалын экспортыг 2021 онд 8.9 сая тн, 2022 онд 9.2 сая тн-д, 2023 онд 9.5 сая тн-д, 2024 онд 10 сая тн-д, алт олборлолтыг 2021-2024 онд 20 тн-д байхаар, уул уурхайн салбарт ажиллагсдын тоог 2021 онд 59400, 2022 онд 60921, 2023 онд 62308, 2024 онд 63188-д хүргэхээр төлөвлөж байна.	
36	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	10.9	12	14.6	27.4	Эдийн засгийн салбаруудын хөгжлийн түвшинг ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ	Үндэсний статистикийн хороо	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 9,555.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс боловсруулах үйлдвэрийн салбар 781,6 тэрбум төгрөг буюу 8.2% эзэлж байна. Мөн Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2022 оны эхний 5 сарын байдлаар 6.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.2 (14.9%) их наяд төгрөгөөр буурсан байна. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 4.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.3 (23.9%) их наяд төгрөгөөр буурахад чулуун, хүрэн нүүрс олборлолт 1.1 (61.3%) их наяд төгрөг, газрын тос олборлолт 375.2 (97.2%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна. Харин металлын хүдэр олборлолт 176.0 (5.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Аж үйлдвэрийн	90

											салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Боловсруулах үйлдвэрийн салбар 1.67 их наяд буюу 25.5 хувийг эзэлж байна.	
40	Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь	хувь	8	70	100	100	Импорт, хэрэглээний хэмжээ, нийт шатахуунд эзлэх хувь, 2015 он суурь түвшин	Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл -тэй холбоотой нарийвчилсан журам болон тус журмын хавсралт	Жилд нэг удаа	2022.06.13-ны өдрийн байдлаар нийт 672,2 мянган тонн шатахуун импортолсон. Үүнд: дизелийн түлш 383 мян.тонн, автобензин 289,3 мян.тонн байгаагаас К5 /Евро-5/ стандартын автобензин 75,621 тонн, дизелийн түлш 70,706 мянган тонн, бүгд 146,327 тонн байгаа нь нийт импортолсон шатахууны 21%-ийг эзэлж байна.	30
	ДҮН											73.3

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР